



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 5/28

Чингис хот

Б.Хуланг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсөвт байгууллагын төлбөр, тооцоо хариуцсан мэргэжилтэн Банзарсүрэнгийн Хулан нь зургаан сараас дээш хугацааны сургалтаар бэлтгэгдэх болсон тул 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Төсөвт байгууллагын төлбөр, тооцоо хариуцсан мэргэжилтний албан тушаалд хүн томилогдох хүртэлх хугацаанд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Төсөвт байгууллагын төлбөр, тооцоо хариуцсан мэргэжилтэн Д.Бадамцэцэгийг 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн томилсугай.

3. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Онончимэг	Санхүү, төрийн сангийн хэлтсийн Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн
	Т.Бямбадулам	Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

4. Б.Хуланд холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР